



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: mbagd@mn.mn; www.rasb.mn

2025. 02. 03 № 07

ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦИИ
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД
Ц.БААТАРХҮҮ ТАНАА

Цахим орчин дахь аюулгүй байдлыг
хангахад чиглэсэн бодлого, үйл
ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаар

Өсвөр үеийнхний цахим хэрэглээний өнөөгийн байдал судалгааны тайландаа "Хүүхдүүдийн 82 хувь нь зүй бус утгатай зурvas и-мэйл, фейсбуукийн хэрэглэгчдээс авдаг, эцэг эхчүүдийн 93 хувь нь хүүхдээ цахим дарамт, дээрэлхэлтэд өртөж байсан, зүй бус зурvas, и-мэйлийн агуулгад гутаан доромжилж нэр төрд халдаж, дарамталсан, хувийн мэдээллийн нууцыг задруулсан, гэмт хэрэгт уруу татах зэрэг үйлдлүүд зонхилдог гэсэн байна. Хүүхдүүдийн 43 хувь нь садар самоууныг сурталчилсан агуулга бүхий мэдээлэлтэй тааралдаж байсан гэж хариулжээ. Хоёр хүүхэд тутмын нэг нь садар самоууныг сурталчилсан мэдээлэлтэй тогтмол тааралддаг, таван хүүхэд тутмын дерөв нь цахимаар зүй бус утгатай зурvas авдаг талаар дурдсан нь цахим орчин дахь хүүхдийн аюулгүй байдал, хүүхдийн эрхийн нөхцөл байдалд онцгой анхаарах шаардлагатайг илтгэж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн бүрэн эрхийнхээ хүрээнд цахим орчин дахь аюулгүй байдал, хүүхдийн эрхийг хамгаалахад чиглэсэн бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаар дараах асуулгыг Танд тавьж байна. Үүнд:


1. Цахим орчин дахь хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн;
2. Монгол Улсад ашиглагдаж буй цахим платформ (*facebook, telegram, viber, Instagram, whatsapp ...*) хэрэглэгчдийг хамгаалах, хуурамч хаяг хэрэглэгчдийн эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээний хэрэгжилт, үр дүн;
3. Хууль бус цахим бооцоот тоглоомын үйл ажиллагааг илрүүлэх, таслан зогсоох талаар хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг Танаас хусье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

О.НОМИНЧИМЭГ



2025000010